

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 5-р сарын 7-ны байдлаар*


2014 оны 5-р сарын 7-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 2.2 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.4 хувиар өссөн байв.

Махны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 4.1 хувь, үхрийн ястай мах 3.6 хувь, адууны мах 3.0 хувь, ямааны мах 2.3 хувь, үхрийн цул мах 1.9 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос хонины ястай мах 1.0 хувь, үхрийн ястай махны үнэ 0.8 хувиар өсч, ямааны мах адууны мах, үхрийн цул махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 5-р сарын 7-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7945 төгрөг, үхрийн /ястай/ мах 8675 төгрөг, үхрийн цул мах 10670 төгрөг, адууны мах 6795 төгрөг, ямааны мах 5780 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 2.7 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, дээд зэргийн савласан гурил өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос 0.9 хувиар өссөн байна. 1-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 8.7 хувь, өмнөх 7 хоногийнхоос 1.2 хувиар өсч, 2-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 2.5 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй бол элсэн чихэр өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг 2).

Зураг 2



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад луувангийн үнэ 1.5 хувиар буурч, байцааны үнэ 1.5 хувь, манжингийн үнэ 0.9 хувиар өсч, төмс болон сонгиноны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ өөрчлөлтгүй, байцаа, лууван, сонгиноны үнэ 0.4 хувь, манжингийн үнэ 0.3 хувиар өссөн байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 2.5 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 9.7 хувиар өсч, задгай сүүний үнэ 1.0 хувиар буурсан, өмнөх 7 хоногийнхоос савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.2 хувиар өсч, “Элекстер” /0.5 л/ савласан сүү, задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос 0.3 хувиар өсч, өндөгний үнэ өмнөх сарынхаас 1.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, харин цөцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 680-1100 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос Булган аймагт 100 төгрөгөөр өссөн байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Булган аймагт 1200 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт 200-1000 төгрөгөөр өсч, Говь-Алтай аймагт 600 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Архангай аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Архангай, Орхон, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар аймагт 70-800 төгрөгөөр өсч, Хөвсгөл аймагт 500 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Төв аймагт 10000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 6000 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Увс, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Сүхбаатар аймагт 200-1000 төгрөгөөр өсч, Говь-Алтай, Завхан, Орхон аймагт 300-1000 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 5250 төгрөг байхад Өмнөговь аймагт 7800 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар малын сүү аймагт 1100-3000 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Өвөрхангай, Өмнөговь аймагт 100-500 төгрөгөөр өсч, Дорноговь, Сүхбаатар аймагт 100 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /3000 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2014 оны 5-р сарын 7-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос Завхан аймагт 100 төгрөгөөр өссөн байна. Нийт аймагт цагаан будаа 1 кг нь 2000-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна. Элсэн чихэр 1 кг нь 1530-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

**ҮСХ-ны Макро эдийн засгийн статистикийн газар
2014 оны 5-р сарын 7**